

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.06.29

Улаанбаатар хот

д/д	д/д	Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хариуцах нэгж, албан тушаалтан
<p style="text-align: center;"><i>Нэг. “Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ алба хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах” арга хэмжээний хүрээнд:</i></p>					
1.	1.	1.Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1.1.1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Захиргааны удирдлагын газар
2.	2.	2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, үр чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	1.2.1.“Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам”; 1.2.2.“ШШГБ-ын алба хаагчийн албан тушаал дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх журам”; 1.2.3.ШШГБ-ын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив; 1.2.4. “ШШГБ-ын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам”-ын төслүүдийг шинэчлэн боловсруулж, батлуулах	Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.	Шийдвэр гүйцэтгэх газар, Захиргааны удирдлагын газар, Санхүү, хангамжийн газар
3.	3.	3. Нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх	1.3.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Захиргааны удирдлагын газар

4.	4.	4. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	1.4.1. ШШГЕГ-ын ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган тогтоох	Ёс зүйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, гомдлыг шалган тогтоож, хариуг хуулийн хугацаанд өгсөн байна.	ШШГЕГ-ын ёс зүйн хороо
			1.4.2. Алба хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх, арга хэмжээ авах	Байгууллагын ёс зүйн хорооны шийдвэрийн санг бүрдүүлсэн байна.	
			1.4.3. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах	Төв, орон нутгийн анги, байгууллагуудын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид анхаарч ажиллах чиглэл, заавар, зөвлөмжийг өгсөн байна.	Дотоод аюулгүй байдал, хяналт, шалгалтын газар
5.	5.	5. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах	1.5.1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр ЭМНДЕГ, ТЕГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан цахимаар мэдээлэл солилцох	Төрийн байгууллагын уялдаа холбоо сайжирч, мэдээллийг түргэн шуурхай солилцох, бичиг хэргийн урсгал зардал буурсан байна.	Шийдвэр гүйцэтгэх газар
			1.5.2. Арилжааны банктай мэдээлэл солилцох ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх		
			1.5.3. Цагдаагийн байгууллагын “Жолоочийн бүртгэлийн сан”-д нэвтрэх эрх авч, шүүхийн шийтгэх тогтоолоор тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах ялаар шийтгүүлсэн ялтны жолоодох эрх болон зөрчлийн талаарх мэдээллийг авах цахим үйлчилгээг нэвтрүүлэх, шаардлагатай техник хэрэгслээр хангах	Ялтанд тавих хяналт сайжирч, мэдээлэл солилцох үйл ажиллагаа шуурхай болсон байна.	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар
<p><i>Хоёр. “Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах” арга хэмжээний хүрээнд:</i></p>					
6.	1.	1. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх	2.1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх, иргэд олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, бодит үнэн зөв мэдээллээр хангах	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	ШШГЕГ-ын газар, хэлтэс, хорих анги,

			2.1.2.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, санал бодлоо солилцох, байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг сурталчлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй эерэг, сөрөг мэдээлэлд тухай бүрт нь тайлбар, хариулт өгөх	Үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал хангагдсан байна.	алба, нэгжийн дарга нар
			2.1.3. Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах	Алба хаагчдын сахилга хариуцлага сайжирсан байна.	
7.	2.	2. Төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	2.2.1.Иргэний шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийн системийг өргөтгөж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлж, төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай зохион байгуулж, төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагаа сайжирна.	Шийдвэр гүйцэтгэх газар
			2.2.2.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талуудад ажиллагааны тухай мэдээллийг онлайн хэлбэрээр өгч, мэдээллийг нээлттэй болгох ажлыг эхлүүлэх	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай зохион байгуулж, талуудыг бодитой мэдээллээр хангасан байна.	
			2.2.3.Шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх лавлагаа, мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд олгох	Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай үзүүлсэн байна.	
8.	3.	3.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	2.3.1.ШШГЕГ-ын үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэх ажлыг зохион байгуулах	ШШГБ-ын хэмжээнд үйлчлүүлж буй хэрэглэгч, иргэд, олон нийтийн хандлага, түүнд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлно.	Захиргааны удирдлагын газар, Санхүү, хангамжийн газар
			2.3.2.Хамтран ажилладаг байгууллага, албан тушаалтан, иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний талаарх судалгааг авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах		
9.	4.	4. Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх	2.4.1. ШШГБ-ын цахим хаягаар өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэлтэд хяналт тавьж, судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомжийн хэрэгжилт,
			2.4.2. Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, харилцах утас, иргэний хүлээн авах уулзах цагийн хуваарийг цахим хуудаст тухай бүр шинэчлэн байршуулах		

			2.4.3. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим хуудсаар мэдээлэх		дотоод ажлын хэлтэс
<i>Гурав. "Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах" арга хэмжээний хүрээнд:</i>					
10.	1.	1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	3.1.1. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавих	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилт хангагдана.	Санхүү, хангамжийн газар
11.	2.	2. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	3.1.2. Тендерийн шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулж, сонгон шалгаруулах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	
<i>Дөрөв. "Хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах" арга хэмжээний хүрээнд:</i>					
12.	1.	1.Хууль сахиулах байгууллагын алба хаагчийн авлига, албан тушаалын гэмт хэргийг олж илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх талаарх мэдлэг туршлага, ур чадварыг сайжруулах	4.1.1. ШШГБ-ын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах 4.1.2. Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон мэргэшүүлэх сургалтад алба хаагчдыг хамруулах	Алба хаагчдын мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадвар сайжирсан байна.	ШШГЕГ-ын газар, хэлтэс, хорих анги, алба, нэгжийн дарга нар
13.	2.	2.Хууль сахиулах байгууллагын алба хаагчийн давтан сургалтын хөтөлбөрийн агуулгад авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх	4.2.1. ШШГБ-ын алба хаагчдад 2017 онд зохион байгуулах албаны сургалтын хөтөлбөрт тусгагдсаны дагуу авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулах	Алба хаагчдын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлнэ.	ШШГЕГ-ын газар, хэлтэс, хорих анги, алба, нэгжийн дарга нар
14.	3.	3. Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх	4.3.1. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан цахимд баталгаажуулах 4.3.2. Алба хаагчдын мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах 4.3.3. Шинээр томилогдсон болон их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагчдаас	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана.	Дотоод аюулгүй байдал, хяналт шалгалтын газар

			тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч, цахим санд оруулах, түүнд хяналт тавих		
<i>Тав. “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах” арга хэмжээний хүрээнд:</i>					
15.	1.	1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	5.1.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигатай тэмцэх газраас тараагдсан материал, гарын авлагыг иргэдэд чөлөөтэй авах орчныг бүрдүүлэх	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирна.	Дотоод аюулгүй байдал, хяналт шалгалтын газар, Хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгж
			5.1.2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, зааврыг алба хаагчдад танилцуулах	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР